

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Шивээговь сумын Орон нутгийн хөгжлийн сан”-гийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2022/06/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Чойр хот 2022 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543156 Цахим хаяг: <a href="mailto:sarantuyab@audit.gov.mn">sarantuyab@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Г.Наранбаяр Утас: 70543179 Цахим хаяг: <a href="mailto:naranbayarg@audit.gov.mn">naranbayarg@audit.gov.mn</a></p> <p>Аудитор: С.Батцэцэг Утас: 70543179 Цахим хаяг: <a href="mailto:battsetsegsa@audit.gov.mn">battsetsegsa@audit.gov.mn</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал .....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	13
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	13
3.9 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.10 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	14
4. Аудитын илрүүлэлт.....	14
4.1 Залруулсан алдаа .....	14
4.2 Төлбөрийн акт .....	14
4.3 Албан шаардлага .....	14
4.4 Зөвлөмж.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг  
Утас/Факс: 976-7054 3179  
И-мэйл: goviusumber@audit.gov.mn

Г ШИВЭЭГОВЬ СУМЫН “ОРОН  
НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН”-ГИЙН  
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ П.ГАНЧИМЭГ  
ТАНАА

᠒᠐᠒᠒.᠐᠘.25 № 50  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шивээговь сумын “Орон нутгийн хөгжүүлэх сан”-гийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Шивээговь сумын “Орон нутгийн хөгжүүлэх сан”-гийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Шивээговь сумын “Орон нутгийн хөгжүүлэх сан”-гийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 240,386.6 мянган төгрөгийн дараах алдаа зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс 237,678.7 мянган төгрөгөөр их байна.

- ОНХС-аар хийгдсэн ажлыг сумын засаг даргын захирамжийн дагуу байгууллагад хөрөнгийн бүртгэл хийгдсэн эсэхэд хяналт тавьж ажиллаагүйгээс нийт 64,605.3 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй
- Зарлагын нийт 50,786.9 мянган төгрөгийн гүйлгээг татварын цахим бүртгэлийн системээр шивэгдсэн эсэхэд хяналт тавьж ажиллаагүй зөрчил илэрсэн.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4.2, 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.9 дэх заалт, УСНББОУС-17,

019090173

Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалаар батлагдсан журмын 5 дугаар зүйлийн 5.1, 6 дугаар зүйлийн 6.5 дахь заалтуудыг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна. заалтыг зөрчсөн ба “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			/ төгрөгөөр /
№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>78,452,913.71</b>	<b>88,580,281.71</b>
2	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>66,014,804.71</b>	<b>31,241,406.71</b>
3	Банкинд байгаа бэлэн мөнгө	66,014,804.71	31,241,406.71
4	Төгрөг	66,014,804.71	31,241,406.71
5	Төрийн сангийн харилцах	66,014,804.71	31,241,406.71
6	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>700,000</b>	
7	Урьдчилж гарсан зардал	700,000	
8	<b>БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>	<b>11,738,109</b>	<b>57,338,875</b>
9	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	11,738,109	57,338,875
10	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>78,452,913.71</b>	<b>88,580,281.71</b>
11	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>5,933,441</b>	
12	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>5,933,441</b>	
13	Өглөг	5,933,441	
14	Бусад өглөг	5,933,441	
15	Байгууллагад төлөх өглөг	5,933,441	
16	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>72,519,472.71</b>	<b>88,580,281.71</b>
17	Засгийн газрын хувь оролцоо	72,519,472.71	88,580,281.71
18	Хуримтлагдсан үр дүн	72,519,472.71	88,580,281.71
19	Өмнөх үеийн үр дүн	68,630,531.71	72,519,513.71
20	Тайлант үеийн үр дүн	3,888,941	16,060,768
21	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>78,452,913.71</b>	<b>88,580,281.71</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /			
№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>274,316,600</b>	<b>301,709,600</b>
2	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>274,316,600</b>	<b>301,709,600</b>
3	Улсын төвлөрсөн төсвөөс	251,407,200	301,709,600
4	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	251,407,200	301,709,600
5	Орон нутгийн төсвөөс санхүүжих	22,909,400	
6	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	22,909,400	
7	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>270,427,659</b>	<b>285,648,832</b>
8	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>270,427,659</b>	<b>285,648,832</b>
9	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>270,427,659</b>	<b>285,648,832</b>
10	Хангамж, бараа материалын зардал	196,322,659	234,315,432
11	Бараа материал шилжүүлсний зардал	196,322,659	234,315,432
12	Бараа үйлчилгээний бусад зардал	74,105,000	51,333,400
13	Бараа үйлчилгээний бусад зардал	74,105,000	51,333,400
14	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>3,888,941</b>	<b>16,060,768</b>
15	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>3,888,941</b>	<b>16,060,768</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /					
№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			68,630,531.71	68,630,531.71
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			68,630,531.71	68,630,531.71
3	Тайлант үеийн үр дүн			3,888,941	3,888,941
4	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			72,519,472.71	72,519,472.71
5	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл			72,519,472.71	72,519,472.71
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			41	41
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			72,519,513.71	72,519,513.71
8	Тайлант үеийн үр дүн			16,060,768	16,060,768
9	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл			88,580,281.71	88,580,281.71

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /			
№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>274,316,600</b>	<b>301,709,600</b>
2	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>274,316,600</b>	<b>301,709,600</b>
3	Улсын төвлөрсөн төсвөөс	251,407,200	301,709,600
4	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	251,407,200	301,709,600
5	Орон нутгийн төсвөөс санхүүжих	22,909,400	
6	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	22,909,400	
7	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>75,105,000</b>	<b>50,633,400</b>
8	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>75,105,000</b>	<b>50,633,400</b>
9	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>75,105,000</b>	<b>50,633,400</b>
10	Бараа үйлчилгээний бусад зардал	75,105,000	50,633,400
11	Бараа үйлчилгээний бусад зардал	75,105,000	50,633,400
12	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>199,211,600</b>	<b>251,076,200</b>
13	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>180,896,224</b>	<b>285,849,598</b>
14	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>180,896,224</b>	<b>285,849,598</b>
15	Дотоод эх үүсвэрээр	180,896,224	285,849,598
16	Бусад хөрөнгө	180,896,224	285,849,598
17	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-180,896,224</b>	<b>-285,849,598</b>
18	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>18,315,376</b>	<b>-34,773,398</b>
19	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	47,699,428.71	66,014,804.71
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	66,014,804.71	31,241,406.71

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү
1	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>367,724,400</b>	<b>336,482,998</b>	<b>31,241,402</b>
2	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>51,033,100</b>	<b>50,633,400</b>	<b>399,700</b>
3	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>51,033,100</b>	<b>50,633,400</b>	<b>399,700</b>
4	Бараа үйлчилгээний бусад зардал	51,033,100	50,633,400	399,700
5	Бараа үйлчилгээний бусад зардал	51,033,100	50,633,400	399,700
6	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>316,691,300</b>	<b>285,849,598</b>	<b>30,841,702</b>
7	Бусад хөрөнгө	316,691,300	285,849,598	30,841,702
8	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>367,724,400</b>	<b>336,482,998</b>	<b>31,241,402</b>
9	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>301,709,600</b>	<b>301,709,600</b>	<b>0,00</b>
10	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	301,709,600	301,709,600	0.00
13	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>66,014,800</b>	<b>34,773,398</b>	<b>31,241,402</b>
14	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	66,014,800	34,773,398	31,241,402
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		66,014,804.71	
16	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		31,241,406.71	

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Шивээговь сумын Орон нутгийн хөгжлийн сан”-гийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдтэй холбоотой цахим татварын системээр зарлагын гүйлгээг хянах, гэрээний дүнгээр шилжүүлэг хийх талаар зөвлөмж өгсөн байна.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Батцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Шивээговь сумын Орон нутгийн хөгжлийн сан” нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/77 дугаар албан бичгээр хуульд заасан хугацаанд ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

“Шивээговь сумын Орон нутгийн хөгжлийн сан”-гийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

- Орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор орон нутгийн төсвөөс санхүүжүүлэгдсэн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ

Тайлант хугацаанд байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Тухайлбал: Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам", Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" тус тус шинэчлэгдэн батлагдсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба 2021 онд “Шивээговь сумын Орон нутгийн хөгжлийн сан”-гийн санхүүгийн болон шилэн дансны үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Шивээговь сумын Орон нутгийн хөгжлийн сан” нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 270,727.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 2,707.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75.0 хувиар буюу 2,030.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

“Шивээговь сумын Орон нутгийн хөгжлийн сан”-гийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10,127.4 мянган төгрөгөөр буюу 13.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, урьдчилгаа, бараа материал, өр төлбөр, Засгийн газрын оролцоо дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	66,014.8	31,241.4	-34,773.4
Авлага	0.0	0.0	0.0
Урьдчилгаа	700.0	0.0	-700.0
Бараа материал	11,738.1	57,338.9	45,600.8
Үндсэн хөрөнгө	0.0	0.0	0.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>78,452.9</b>	<b>88,580.3</b>	<b>10,127.4</b>
Өр төлбөр	5,933.4	0.0	-5,933.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	72,519.5	88,580.3	16,060.8
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>78,452.9</b>	<b>88,580.3</b>	<b>10,127.4</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 31,241.4 мянган төгрөг болж 34,773.4 мянган төгрөгөөр буурсан байна. Эхний үлдэгдлээс зарцуулалт хийгдсэн байна.

Урьдчилгаа данс 700.0 мянган төгрөгөөр буурч үлдэгдэлгүй тайлагнасан байна.

Бараа материал дансны үлдэгдэл нь 57,338.9 мянган төгрөг болж 45,600.8 мянган төгрөгөөр өссөн нь гүйцэтгэл гараагүй буюу он дамжсан ажлыг нөөц хөрөнгөд бүртгэснээс шалтгаалжээ.

Өр төлбөр данс үлдэгдэлгүй бөгөөд өмнөх оны өглөгийг бүрэн барагдуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 88,580.3 мянган төгрөг болж 16,060.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

“Шивээговь сумын Орон нутгийн хөгжлийн сан”-гийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 27,393.0 мянган төгрөгөөр буюу 10 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 15,221.2 мянган төгрөгөөр буюу 5.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал шилжүүлсний зардал байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд өөрчлөлт ороогүй байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Төсвийг төлөвлөдөггүй ба сумын ИТХ-аар хэлэлцүүлж дараа онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг баталдаг байна. Шивээговь сумын ИТХ-ын 2020 оны 09, 2021 оны 04 дүгээр тогтоолоор шилжих хөрөнгө оруулалт 11,733.4 мянга, шинээр эхлэх хөрөнгө оруулалтад 11 их засварт 219,705.2 мянга, 5 бараа, тоног төхөөрөмж 68,082.0 мянга, 7 хөтөлбөр, арга хэмжээнд 51,033.1 мянга, 2 зөвлөх үйлчилгээнд 17,170.7 мянга, нийт 367,724.4 мянган төгрөгийг баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “70503-орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт” хөтөлбөрийн “80918-бусад”, “83112-хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал” арга хэмжээг санхүүжүүлэхээр 367,724.4 мянган төгрөгийн төсөв баталснаас Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих 301,709.6 мянга, 2020 оны үлдэгдлээс 66,014.8 мянга, нийт 367,724.4 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 301,709.6 мянга, урьд оны үлдэгдлээс 34,773.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд 336,483.0 мянган төгрөгийг зарцуулж, 31,241.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 336,483.0 мянган төгрөг буюу 91.5 хувьтай байгаа нь нийт хөрөнгө оруулалтаас гэрээний хэмнэлт 1,070.1 мянга, шилжсэн хөрөнгийн зардал 22,602.4 мянга, хөтөлбөр төсөл, арга хэмжээний хэмнэлт 7,568.9 мянган төгрөг байна.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

“Шивээговь сумын Орон нутгийн хөгжлийн сан” нь нэмэлт санхүүжилтийн дансгүй байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Аудитаар Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2021 оны А/108, А/111 дүгээр тушаалаар батлагдсан ерөнхий чиглэлд тусгагдсан асуудлыг онцлон авч үзсэн.

### **3.8 Аудитын гол асуудал**

Аудитад нөлөө үзүүлэх онцлох асуудал байхгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

“Шивээговь сумын орон нутгийн хөгжлийн сан” нь 2021 онд нийт 675,442.0 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 123,924.2 мянган төгрөгийн 24 мэдээллийг ил тод байршуулаагүй, 21 удаагийн мэдээллийг хугацаа хоцроосон зөрчилтэй байна.

Иймд дээрх зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага өгч ажиллалаа.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.9 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 189,215.5 мянган төгрөгийн 5 алдаа, зөрчил илэрснээс, 13,745.9 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж, 175,469.6 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага өгсөн бөгөөд албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 100.0%-тай байна.

Хүснэгт 2 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-	-	-
Албан шаардлага	2	175,469.6	2	175,469.6	-	-	-
Зөвлөмж	3	13,745.9	3	13,745.9	-	-	-
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>189,215.5</b>	<b>5</b>	<b>189,215.5</b>			

### Дараагийн аудитаар анхаарах асуудал

“Шивээговь сумын орон нутгийн хөгжлийн сан”-д анхаарах асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 240,386.6 мянган төгрөгийн 4 алдаа, зөрчил илэрснээс 188,529.5 мянган төгрөгийн 2 зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 51,857.0 мянган төгрөгийн 2 зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын залруулга хийгдээгүй байна.

### 4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй байна.

### 4.3 Албан шаардлага

**4.3.1** Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш худалдан авалтыг мэдээлсэн боловч 8 мэдээлэл мэдээлээгүй, хөрөнгө зарцуулахтай холбоотой 16 тушаал шийдвэр мэдээлээгүй, 21 удаагийн мэдээлэл хоцроосон зэрэг нийт 123,924.2 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.4, 6.4.8, 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.3, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2.2.5, 2.2.3.2, 3 дугаар зүйлийн 3.1.7, 3.2.9 дахь заалтуудыг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

**4.3.** ОНХС-аар хийгдсэн ажлыг сумын засаг даргын захирамжийн дагуу байгууллагад хөрөнгийн бүртгэл хийгдсэн эсэхэд хяналт тавьж ажиллаагүйгээс нийт 64,605.3 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4.2, 20 дугаар зүйлийн 20.2.4, Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалаар батлагдсан журмын 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.1-т заасны дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Зардлын данстай холбоотой асуудал**

###### **1.1. Илрүүлэлт:**

Зарлагын гүйлгээг татварын цахим бүртгэлийн системээр шивэгдсэн эсэхийг хянаж тулгаагүй нийт 50,786.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.4, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан журмын 6 дугаар зүйлийн 6.5 дахь заалтуудыг зөрчсөн, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаж ажиллаагүй байна.

###### **1.2. Өгсөн зөвлөмж:**

Зарлагын гүйлгээг татварын цахим бүртгэлийн системээр сар бүр хянаж тулгах

##### **2. Дотоод хяналттай холбоотой асуудал**

###### **2.1. Илрүүлэлт:**

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлыг гүйцэтгэлийг санхүүжүүлэхдээ гэрээ байгуулсан үнийн дүнгээс 1,070.1 мянган төгрөгөөр дутуу шилжүүлсэн боловч өглөг үүсгээгүй зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх заалтуудыг зөрчсөн, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаж ажиллаагүй байна.

###### **2.2. Өгсөн зөвлөмж:**

Ажлын санхүүжилтийг гэрээний дүнгээр шилжүүлэх, өглөг үүсгэхгүй байх

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мян төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Шивээговь сумын ОНХС	4	240,386.6	-	-	-	-	2	188,529.6	2	51,857.0